

Үйлчлүүлэгчид чиглэсэн хүүхдийн сайжралын үнэлгээ (COSI-C) ба зорилго төлөвлөлтийн зааварчилгаа

Оршил

Үйлчлүүлэгчид чиглэсэн сайжралын үнэлгээний эх хувилбар нь насанд хүрсэн үйлчлүүлэгчид маш хэрэгцээтэй боловч хүүхдийн практикт хэрэглэхэд хэд хэдэн сул талтай. Хүүхдийн зорилго/хэрэгцээ нь насанд хүрэгчдийнхээс ихээхэн ялгаатай бөгөөд энэ нь “Өөрчлөлтийн зэрэг”, “Эцсийн чадвар” зэрэг үйлчлүүлэгчид чиглэсэн сайжралын үнэлгээг тооцоход бэрхшээлтэй байдаг. Энэхүү асуудалд тулгуурласан хувилбарыг үйлчлүүлэгчид чиглэсэн хүүхдийн сайжралын үнэлгээ гэх бөгөөд сайжралын үнэлгээний суурь дизайныг оролцуулан зарим өөрчлөлтийг хүүхдэд илүү тохиромжтой байхаар зохиосон.

Маягтыг хэрхэн ашиглах вэ

Сонсгол судлаач болон гэр бүл нь нэг эсвэл хэд хэдэн **зорилго** болон боломжит **төлөвлөгөөг** гарган түүнийгээ биелүүлдэг. Эдгээрийг өгсөн зайд тэмдэглэнэ.

Зорилгуудын хугацааг нягтлан, өгөгдсөн зайд тэмдэглэнэ. Энэ нь зорилго тус бүрт ижил эсвэл ялгаатай ч байж болно. Зарим үед дараагийн хяналтын үзлэгтэй давхцана эсвэл зорилгоосоо өмнө давтан үзэх хэрэгцээ гарч болно. Жишээ нь: хэрвээ хүүхэд өөрсдөө сонсголын аппаратны тохируулгыг зохицуулах зорилготой байвал энэ нь 6 сараас илүү хугацаанд үргэлжлэх хэдий ч сайн тохируулахын тулд давтан үзлэгийг илүү хурдан, ойр товлоно.

Товлосон хугацаанд **өөрчлөлтийн зэргийг** үнэлэх ба зорилго биелэгдээгүй тохиолдолд сонсгол судлаач нь гэр бүлийнхэнтэй зөвлөлдөж шийдвэрлэнэ:-

1. Одоогийн төлөвлөгөө зохимжтой байгаа ч илүү цаг хугацаа шаардлагатай. Давтан үзлэгийн шинэ товлолыг зорилгын зэргэлдээ бичнэ.
2. Одоогийн төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай. Шинэ төлөвлөгөөний дэргэд шинэ төлөвлөгөө, шинэ хугацааг тэмдэглэ эсвэл зорилго байхгүй бол төлөвлөгөө, хянан үзэх шинэ хугацааг бичнэ. Хэрэв зорилгыг дахин бичихээр бол анх зорилгыг сануулахаар бичигдсэн хэсгийн “зорилго биелэгдсэн” баганад * /од/ тэмдэглэгээг хийнэ. Энэ нь хэдийгээр зорилго биелэгдээгүй ч мартагдахгүй юм.
3. Зорилго биелэгдэх боломжгүй, цаашид эцэг эхчүүдэд нэн тэргүүний зорилт байхаа больсон, эсвэл цаашид хүчингүй. Ийм тохиолдолд хэдийгээр зорилго биелэгдээгүй ч сануулга болгох зоригор “зорилго биелэгдсэн” баганад * /од/ тэмдэглэгээг хийх бөгөөд цаашид дахин хэлэлцэх шаардлагагүй.

COSI™-C

Үйлчлүүлэгчид чиглэсэн
хүүхдийн сайжралын үнэлгээ



Хүүхдийн нэр: _____

Сонсгол судлаач: _____

	Давтан үзлэгийн он сар өдөр	Өөрчлөлтгүй	Бага өөрчлөлттэй	Мэдэгдэхүйц өөрчлөлттэй	Зорилго биелэгдсэн
Зорилго _____ _____ Төлөвлөгөө _____ _____ _____					
Зорилго _____ _____ Төлөвлөгөө _____ _____ _____					
Зорилго _____ _____ Төлөвлөгөө _____ _____ _____					
Зорилго _____ _____ Төлөвлөгөө _____ _____ _____					